

БАТЛАВ.  
ЭРДЭНЭСАНТ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА

Т.МӨНХЗОРИГ

БЭЛЧЭЭРИЙН ХУДАГ ГАРГАХ АЖЛЫН ДААЛГАВАР

1. Ерөнхий мэдээлэл

Захиалагчийн нэр	Эрдэнэсант сумын ЗДТГазар
Бараа, ажил үйлчилгээний нэр	Бэлчээрийн худаг гаргах
Тендер шалгаруулалтын дугаар	ТӨАЭССЗДТГ/20240201008
Байршил	5-р багт бэлчээрийн худаг "Талын бор"
Зориулалт	Иргэд, мал амьтны ундны усан хангамжийг нэмэгдүүлэх
Ашиглалт	Жилийн 4 улиралд ашиглана.

2. Техникийн тодорхойлолт

№	Үзүүлэлтүүд	Тендерт оролцогчийн санал
<b>1. Цооног өрөмдөх, цооногийг тоноглох</b>		
1.1	Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтоох	
1.2	Цооногийн ашиглалтын ундарга: 2м3-6м3 ус өгөх хүчин чадалтай байна.	
1.3	Суултын яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.	
1.4	Шүүрийн яндангийн материал нь ган ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.	
1.5	Ус өргөх яндангийн диаметр 25мм-ээс багагүй, материал нь төмөр ган яндан байх ба ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн, хүйтний улиралд тэсвэртэй байх.	
	Ус шүүх хайрга нь шигшсэн мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 105мм-ээс томгүй байна.	
1.7	Тунгаагуурын хэмжээ нь: 2м-ээс багагүй.	
1.8	Худгийн шавхалт хийж цэвэрлэх хугацаа: 24 цагаас багагүй.	
1.9	Усны чанарын сорилт авах шинжилгээ хийлгэсэн байна.	
1.10	Худгийн өрөмдлөгийн гүн: 50м-ээс багагүй цооногтой байна.	
<b>2. Худгийн байгууламж бүх багт</b>		
2.1	Хэмжээ /дотор талдаа, цэвэр зай/ 3:2,5м, ханын өндөр шалнаас дээш 2м-ээс багагүй байна.	

2.2	Материал: Блок, банз	
2.3	Худгийн байрны хаалга бат бөх байдлаар хийгдсэн байна.	
2.4	Худгийн дээр 30см х 30см хэмжээтэй нээлхийг тохируулан хийнэ.	
2.5	Худгийн цонх нь 40х50см хэмжээтэй байна. /Цонхны байрлал нь мал услах онгоцны чанх урд байна/	
2.6	Ундны ус авах хоолой нь: 60мм диаметртэй, ган хоолойг цонхны дор гаргах /ундны ус авахад тохиромжтой байдлаар уртыг сонгох/	
2.7	Мал услах онгоцонд ус өгөх хоолой нь: 60мм диаметртэй, ган хоолойг цонхны доороос гаргах	
2.8	40 мм-ын диаметртэй цоорхойг генераторын утааг гадагшлуулах зорилгоор генераторын янданд яг тохируулан тохиромжтой байрлалд гаргана.	
2.9	Босоо суурьтай тоноглогдсон, ундны усанд зориулагдсан угсардаг 1.5м <sup>3</sup> -ээс багагүй багтаамжтай дээгүүрээ тагтай нөөцийн сан	
<b>3. Мал услах онгоц</b>		
3.1	<ul style="list-style-type: none"> <li>• Хэмжээ: 9м-ээс багагүй урттай. 400мм-ийн голчтой хагас цилиндр</li> <li>• Материал: Ган хоолой буюу цутгамал төмөр бетон</li> <li>• Худгийн байшингаас 1-2 хэмийн налуутайгаар 2м-ийн зайд байрлуулна.</li> <li>• Онгоцны адагт үлдэгдэл ус юүлэх жижиг нээлхий гаргана. /Нээлхийг онгоцонд ус өгөх үед эрэгдэж хаадаг байхаар хийнэ.</li> <li>• Онгоцыг ган яндангаар хийсэн үед ирмэгийг аюулгүй болгож засна.</li> <li>• Усан сангаас мал услах онгоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн доод ёроолын усыг бүрэн шавхахаар байрлуулж гагнана.</li> </ul>	
3.2	Мал услах онгоцны хоёр талд м урттай. 0.5м өргөнтэй цементэн хавтангаар мал услах талбай хийнэ.	
<b>4. Худгийн насос, бага оврын генератор</b>		
4.1	Бага оврын генератор: Бинзен болон дизелээр ажилладаг /ISO стандартын шаардлага хангасан/ Монгол орны уур амьгалын нөхцөлд ашиглах боломжтой 220В -ын цахилгаан үүсгүүр бүхий насос байна.	
4.2	Гүний насос: IS09001 стандартын шаардлага хангасан, Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх.	